

хүсэлтэй холбоотой. Хятадын төр улс хэрвээ нүүдэлчид үгүйрэн хоосрох юм бол аюулд учран сөнөж мөхнө хэмээн тооцож байв. Тэд чухамхүү ядуурал хоосрол л нүүдэлчдийг хятад нутагт уулгалан хэрэгцээт зүйлээ булааж авах замд түлхдэгийг ухаардаггүй байв. Эдгээр эдийн засгийн шалтгаанаар дайн дажин гарах үест газар тариалангийн улсууд эцэстээ нүүдэлчин ард түмэнд Их цагаан хэрмийн дагуу арилжаа наймаа хийх эсвэл тэдний шаардсан үр тариа, эд бараа зэргийг өгч салдаг байлаа. Тиймээс ч хэрвээ нүүдэлчид оршин тогтнохын тулд хэрэгцээт зүйлээ сэлбэх зайлшгүй шаардлага гарвал тэд хүчирхэг цэрэг нөөж хуралдуулан өмнө этгээдэд халддаг түүхтэй. Харин орос болон манж нар Төв болон зүүн хойд Азийг эзэлсний дараа эдийн засгийн талаар хавчих бодлогоо орхиж нүүдэлчидтэй арилжаа наймаа хийхийг хөхүүлэн дэмжих болов. Энэ бодлого нь худалдаачдад ихээхэн ашигтай, нүүдэлчин ард түмэнд ч дөхөмтэй боллоо. Тэд нар мал аж ахуйн бүтээгдэхүүнээ гэрийнхээ хаяанд л хүссэн бараагаар солих бололцоо олов. Хэдийгээр худалдаачдын залилж мэхлэх нь багагүй боловч дайн дажин хийж байснаас ийм хэлбэр нь монголчуудад ээлтэй байлаа. Ийнхүү нүүдэлчин ард түмэн амьдралын үндсэн шаардлагаар нэгдэж нягтран нэгэн зорилгын төлөө тэмцэх түүхийн хэрэгцээ нэгэнт улиран оджээ.

Англи хэлнээс орчуулсан **Ц. Батбаяр**

БНМАУ, МАНЖ-ГО УЛСЫН ХООРОНДЫН ХИЛИЙН ХЭЛЭЛЦЭЭ

Д.Гомбосүрэн*

БНМАУ, Манж-го улсын төлөөлөгчдийн хооронд 1935 оны 6-р сарын 3-наас 1941 оны 10-р сарын 15 хүртэл завсарлагаатайгаар, хэд хэдэн үе шаттай үргэлжилж, «Монгол-Манжуурын бага хурал» хэмээн түүхэнд орсон энэ хэлэлцээнд хоёр тал хэрхэн бэлтгэсэн, ямар ямар бодлого баримталсан, хэлэлцээний явц, төгсгөл, түүнийг амжилттай дуусгасан бол Алс Дорнод болон БНМАУ-ын гадаад байдалд хэрхэн нөлөөлөх байсан зэрэг олон асуудлыг судалж, хөндөж ярихгүй байсаар өнөөг хүрчээ. БНМАУ-ын 1930-аад оны гадаад бодлогын үйл ажиллагаанд томоохон байр эзлэх энэ хэлэлцээний талаар товч өгүүлье.

х х х

БНМАУ-ын Засгийн газар бүр 1931 онд Японы цэрэг Манжуурыг түрэмгийлэн эзэлсэн цагаас эхлэн, тус орны Дорнод хязгаар түгшүүртэй болж, дайн байлдааны аюул тулгарч болозшгүйг ойлгож, тухайн нөхцөл байдлыг эеэвээр шийдвэрлэхийг зорьж байлаа.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Бага Хурал, Засгийн газар, МХЗЭ-ийн Төв Хороо, Үйлдвэрчний Төв Зөвлөл зэрэг нам, төр, олон нийтийн байгууллагын идэвхтний хурал 1931 онд болж, Японы эзэрхэг түрэмгий нараас Манжуурыг цэргийн хүчээр эзэлсэн нь ЗСБНХУ, БНМАУ-ын дорнод хязгаарыг түгшүүртэй болгож байгааг онцлон тэмдэглээд: «...Манжуурт байсан хэргийг сайтар ширтэн харж, тус орныг

* Цэргийн түүхийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, дэд эрдэмтэн, хурандаа.

хамгаалах явдлыг бэхжүүлж, Ардын улаан цэргийн сүр хүчийг бадруулж, найрамдлын бодлогыг баримталж...»¹ явуулахыг ард түмэндээ уриалсан тогтоол гаргасан байна. Манай гадаад бодлогын энэ чиг шугам 1930-аад оны дунд үе хүртэл тууштай хэрэгжиж байсны дээр МАХЦ-ийн командлал аливаа будиланаас зайлсхийхийн тулд улсын хил дээр буу дуугаргахгүй байх тушаалыг хязгаарын цэрэгтээ өгсөн байв. Гэтэл дэлхий дахины хэвлэлд 1935 оны 1-р сарын 24-нд БНМАУ ын хязгаарын цэргийн ангиуд Бойр нуурын орчноор Манж-го улсын хилийг давж, Манжуурын отрядыг халдан довтолсон тухай олон мэдээ гарсан байна.

Монгол-Манж-Гогийн хил дээр болсон анхны зэвсэгт мөргөлдөөн нь хоёр орны хилийн асуудал, цаашилбал, Монгол-Манжуурын бага хурлыг ойлгоход дөхөм үзүүлж байгаа юм. Уг мөргөлдөөнтэй холбогдуулж, БНМАУ-ын ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд П. Гэндэн 1935 оны 1-р сарын 26-нд хийсэн мэдэгдэлдээ дээрх мэдээ нь үнэн байдалд нийцэхгүй гэж няцаагаад «Чухамдаа нэг сарын 24 ний 13. 00 цагт Манжуурын талаас 17 зэвсэг бүхий этгээдүүд БНМАУ ын хил хязгаараас 20 км* дотогш нэвтэрч, мөн улсын нутаг Халхын сүмийн орчим ирснийг манай улсын хязгаарыг сэргийлэх отрядаас үзэж мэдсэн амой. Эл учрыг олохын тулд явсан хэсгийн дарга Дондовоос хүрэлцэн очмогц тэд нараас түүний биеийг барин авахыг завдахад Мөн Дондовоос баригдахгүйг хичээж биеэ хамгаалахын завсар хүнд шарх олоод үхжээ. Үүний дараа харилцан буудалцсаны улмаас хоёр этгээдэд сүйтгэл автагдал тохиолдсон амой. Учир иймд БНМАУ-ын Засгийн газраас будлианы учрыг уг газар дээр нь нарийн тодорхойлохоор харуцлагатай хүмүүсийг нэн даруй томилохоор тогтоожээ»² гэжээ.

Цааш нь бас Халхын сум хэмээх нутаг болбоос аль эртнээс янагш халх монголчуудын үндсэн нутаг мөн бөгөөд 1921 оноос эхлэн БНМАУ ын бүх газар дэвсгэрийн нэгэн хэсэг болох бөгөөд түүний суулгасан хязгаарыг сэргийлэх харуул байсаар ирснийг цохон тэмдэглэжээ.

Бас энэ үеэр Бойр нуурын дэргэд болсон хилийн мөргөлдөөнд Зөвлөлтийн нисэх онгоцууд Хайларын ойролцоох тосгоныг буудсан тухай гадаадын хэвлэл мэдээллээр шуугиан дэгдсэнийг ТАСС бүрэн эрхийнхээ ёсоор няцаасан байна³.

Дээрх мэдэгдлүүдтэй холбогдуулан Японы Гадаад явдлын яамны төлөөлөгч 1935 оны 1-р сарын 28-нд «Манжуурын Засгийн газар хэрэг явдлыг газар дээр нь зохицуулах хэлэлцээ хийхийг Хянганы хилийн хамгаалах ангид санал болгов» гээд цааш нь гадаадын сурвалжлагчдлын асуултад хариулахдаа «энэ мөргөлдөөн нь Манж-го ба Гадаад Монголын хооронд хил «тодорхой бус» байснаас үүдсэн тул үүнээс урьдчилан сэргэмжлэх хамгийн сайн арга бол хил тогтоох явдал юм» хэмээжээ.⁴

Ийнхүү БНМАУ, Манж-го улс хоёр хилийн мөргөлдөөнийг хэлэлцээний замаар шийдвэрлэхэд шуурхай бэлтгэж эхлэв. Хэлэлцээ хийх саналыг аль тал сэдсэн болон энэ нь ямар зорилготой байсан нь сонирхолтой юм. Үүнийг тодотгоход Манж-гогийн Хянган мужийн хойд цэргийн сайдаас 1935 оны 2-р сарын 1-нд Монголын талд ирүүлсэн хоёр захидал дэм болно.

Эхний захидалд: «Манай Манж-гогийн цэрэг бол хилийг тогтоох зорилготой ямар газар, хэзээ уулзахыг хэлэлцэж тогтохоор хүрэлцэн ирсэн тул даруй яаравчлан хариу өгөхийг хүсэх ба бид нараас өөрийн төлөөлөгчдийг тогтсон газар зохих хугацаанаа болзооны до-

* Эх баримтад 2 км гэхийг 20 км гэж алдсан бололтой.

тор илгээмэй, Хил хязгаарыг нарийн чандаар тогтоох аваас хил хязгаар нэвтрэлцэх буюу дайн байлдаан үүсгэх явдал үгүй болно»⁵ гэсэн бий.

Удаах захидалд: «Хүндэт цэргүүд ээ! Үүнээс хойш Халхын голыг нэвтэрч үл болно. Бид нар дайн байлдааны янзтай бус харин амгалан тайван, нам гүм байдалтай байваас зохимой. Хэрэв үүнийг та нараас анхаарах, хайхрахгүй аваас цэргийн хүчийг хэрэглэхэд хүрэх бөгөөд тухайн хариуцлагыг танай цэрэгт тохмой»⁶ хэмээн тулган шаардсан байна.

Дээрх захидлуудыг Монголын тал хүлээн аваад 1935 оны 2-р сарын 4; 1935 оны 2-р сарын 5; 1935 оны 2-р сарын 6-ны өдрүүдэд хариу өгсөн юм. Энэ баримт бичгийн нэгийг бүрэн эхээр нь сийрүүлбэл:

«Хянган мужийн хойд цэргийн сайд Танаа. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас хоёр этгээдийн төлөөлөгчид нь манай хоёр улсын хэрэгт үл хамаарсан ба манай хоёр улсад ойр бөгөөд тус тусын төвд харилцахад дөхөм СССР улсын дэвсгэр дээр оршиж бүхий Улаан-Үд хотноо уулзаж уг хэлэлцээг гүйцэтгэхэд дөхөм болохыг шийдвэрлэж мэдэгдэхийн тулд миний бие төлөөлсөн бөлгөө.

Манай талаас томилогдсон төлөөлөгчид нь Гадаад явдлын яамны дэд сайд М. Дугаржав, Цэргийн яамны дэд сайд О.Дашчирэв, Засгийн газрын түшмэд Д.Догсом нарыг тус тус томилсон бөгөөд хоёр этгээдийн төлөөлөгчид уулзаж уг хэлэлцээг 2-р сарын 10-ны өдөр эхлэх явуулахыг хүсэхээс гадна энэхүү хэлэлцээнд зууч болгон СССР ийн төлөөлөгчийг суулцуулахыг хүсмой.

Дээр дурдсан саналын тухай хариу ба танай талаас томилсон төлөөлөгчдийн нэрийг тус тус даруй мэдэж, өөрийн Засгийн газар мэдэгдэхийг хүсэж байна.

БНМАУ-ын зүүн хязгаарыг сэргийлэх
цэргийн дарга, хурандаа Гочоо
25 (1935) оны 2 сарын 5 өдөр⁷ гэжээ.

Манж-го улсын Засгийн газар дээрх нотыг хүлээн аваад 1935 оны 2-р сарын 13, 1935 оны 2-р сарын 15-нд ирүүлсэн хариу бичигтээ хэ Дэлцээг БНМАУ, Манж-Го улсын аль нэгний нутаг дээр явуулах, уг газрыг тогтсоны дараагаар эхлэх хугацааг тогтоох тухай мэдэгдээд төлөөлөгчдийнхөө урьдчилсан бүрэлдэхүүнийг ирүүлсэн байна.⁸

Ийнхүү БНМАУ, Манж-го улсын Засгийн газрын хооронд хилийн хэлэлцээ хийх талаар дипломат шугамаар олон удаа харилцаж, санал солилцсоны эцэст тохиролцоонд хүрснээр «Монгол-Манжуурын бага хурал» хэмээн нэрлэгдэх болсон хэлэлцээ Манжуур өртөөн дээр эхэлжээ.

Анхдугаар бага хурал.

Монгол-Манж-гогийн анхдугаар бага хурлын эхний шат 1935 оны 6-р сарын 3-наас 1935 оны 8-р сарын 25-нд болсон байна.

Монголын Засгийн газрын төлөөлөгчийн даргаар Цэргийн яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 2-р орлогч Г.Самбуу; гишүүдэд Г.Дамба, Д. Догсом, мөн нарийн бичгийн дарга Догсүрэн, дипломат курьер Чимэддорж, ажилтан Жавган, Лувсандэндэв, орчуулагч Журамт нар оролцжээ.

Манж-гогийн талаас: төлөөлөгчдийн тэргүүн Лин Шинь, гишүүдэд Манж-го улсын ГЯЯ-ны улс төрийн хэлтсийн дарга Канки, Манжуур дахь Японы цэргийн төлөөлөгчийн газрын дарга хошууч Сакурай, ажилтан Сайто, Инокучи нар оролцсон бололтой.

Монгол, Манж-го улсын анхдугаар бага хурлын эхний шатны гол үр дүн нь тус хоёр улсын хил дээр 1935 оны 1-р сарын 24-нд гарсан Халхын сүмийн будлиан болон цаашид гарч болох элдэв будлианыг тайван замаар шийдвэрлэх үүрэг бүхий хамтарсан хилийн комисс байгуулж, бүрэн эрхт төлөөлөгчийг солилцох талаар харилцан тохирч, энэхүү хэлэлцээрийг цаашид үргэлжлүүлэх эрхийг Манжуур өртөөн дээр 1935 оны 6—8-р сард хэлэлцээ хийсэн тус тусын төлөөлөгчдөд хариуцуулсанд оршино.

Монгол, Манж-го улсын анхдугаар бага хурлын хоёр дахь шат нь 1935 оны 10-р сарын 2-ноос 1935 оны 11-р сарын 25-ны өдрүүдэд Манжуур өртөөнд явагдсан байна. Хэлэлцээний энэ шатанд хилийн будлианыг зохицуулах холимог комисс байгуулах, хилийн бүрэн эрхт төлөөлөгчдөө солилцох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцжээ.

Бага хурлын 10-р сарын 2, 4, 5, 7-ны өдрийн хуралдаанаар хоёр талын саналыг үргэлжлэн хэлэлцжээ.

Монголын төлөөлөгч тал бүрээс хилийн бүрэн эрхт төлөөлөгч нэгийг томилох санал оруулж хэлэлцүүлсэн байна. Үүнд, Монголын бүрэн эрхт төлөөлөгч Манжуур өртөөнд байнга суух бөгөөд Манжуурын бүрэн эрхт төлөөлөгч БНМАУ-д Тамсаг сумд байрлана. Монголын талын саналаар Манжуур өртөөнд байгаа Монголын хилийн бүрэн эрхт төлөөлөгч Манжуурын орон нутгийн эрх баригчдын төлөөлөгчтэй, харин Тамсаг сумд суугаа Манжуурын бүрэн эрхт төлөөлөгч Монголын орон нутгийн эрх баригчдын төлөөлөгчтэй хамтран анхан шатны хоёр комисс байгуулах бөгөөд Монгол-Манжуурын хилийн холбогдох хэсэгт үүссэн бүх мөргөлдөнийг дээрх комиссууд шийдвэрлэнэ гэжээ.

Монголын төсөл нь ийнхүү хилийг хоёр том хэсэгт хувааж байгаа бөгөөд аль хэсэг дээр мөргөлөн үүссэнээс хамааран үг асуудлыг Тамсаг сумд юм уу Манжуур өртөн дээр авч үзэх болно. Хэрэв анхан шатны хоёр комисс мөргөлдөөнийг шийдэж чадахгүй бол БНМАУ, Манж-го улсын Засгийн газрын хилийн бүрэн эрхт төлөөлөгчөөс бүрдсэн хилийн холимог комисст эцсийн шийдвэр гаргуулахаар шилжүүлнэ хэмээн Монголын саналд тусгасан байна.⁹

Манж-гогийн төлөөлөгчид өөрийн саналыг (Бүрэн эрхт төлөөлөгч 3-ыг томилох-Д. Г.) тулган хүлээлгэх, шахалт үзүүлэх зорилгоор 10-р сарын 9-ний хуралдаанд оролцохоосоо татгалзжээ. Мөн Манж-гогийн төлөөлөгчдийг толгойлж байсан Канки Монголын төлөөлөгчдийн гишүүн Д. Догсом, Г.Дамба нартай уулзаж: «Манай саналыг зөвшөөрөхгүй бол танай улсыг тусгай улс хэмээн үзэхгүй бөгөөд шууд хоёр улсын хүчийг үзэх, төв нийслэлийг хүрэх... Үүнийг сайтар бодож дараагийн хурал дээр ямар шийдвэр гаргахыг үзэж байж болно»¹⁰ гэж мэдэгджээ.

Эдгээр хэрэг явдлын дараагаар Монголын төлөөлөгчийн тэргүүн Г. Самбуу хэлэлцээг зогсоосон тухай 1935 оны 11-р сарын 25-нд мэдэгдээд дараа өдөр нь тэд Манжуур өртөөнөөс Улаанбаатар руу буцжээ.

Хэлэлцээ тасарсны дараагаар Япон-Манж-гогийн тал дэргийн ихээ Хэн хүчээр БНМАУ-ын Дорнод Хилд халдан довтолж, түрэмгий ажил лагаагаа идэвхжүүлсэн билээ. Зарим баримт үзье.

1935 оны 12-р сарын 24-1936 оны 4-р сарын 1 хүртэл 11 удаа хил зөрчин халдаж довтолсны томоохон нь:

1936 оны 3-р сарын 29-нд Япон - Манж-гогийн тал 7 ачааны машинтай отрядаар Адагдулааны заставыг, мөн өдөр хоёр машин хэргээр Буландэрсний заставыг довтолжээ. Төдөлгуй 1936 оны 3-р сарын 31-4-р сарын 1-нд хэдэн арван авто машинтай, их буу, танк, хуягт ма-

шин, нисэх онгоцоор дэмжүүлсэн томоохон хүчээр довтолж, Алтагдулааны заставыг эзлэн, улмаар Тамсагбулагийн чиглэлд давшсан боловч МАХЦ-ийн ангиудад бут цохигдсон байна.

БНМАУ-ын Засгийн газар дээр өгүүлсэн хилийн будлианы талаар 1936 оны 1-р сарын 18, 24; 2-р сарын 13, 29; 3-р сарын 14, 27-нд Манж-гогийн Засгийн газарт эсэргүүцлийн нот, цахилгаан удаа дараа явуулж, Монгол-Манж-Гогийн хилийг тодотгох холимог комиссыг нэн яаралтай байгуулж, ажилд нь оруулахыг шаардаж байв.

Манж-гогийн Гадаад явдлын яамны сайдаас 1936 оны 4-р сарын 10-нд БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд А. Амарт явуулсан нотод дурдахдаа: Монголын цэргүүдээс 3-р сарын 29, 31-нд «Хууль бус хэргүүдийг өдүүлсний тухай» манай эсэргүүцлийг хайхрахгүй байгаад харамсаж байгаагаа мэдэгдээд цааш нь «хойшид гарч болох зөрчил тэмцээнүүдийг нэг тийш болгох ба урьдаас сэргийлэх арга хэмжээнүүдийг авах явдал нь одоо үеийн хойшлуулж үл болох явдал мөн»¹¹ хэмээсэн бий.

Мөн нот бичигт Манж-гогоос байнга суух төлөөлөгчдийн газрыг Баянтүмэн Тамсаг сүмд байрлуулах, 1936 оны ээлжит хуралдааныг Баянтүмэнд хуралдуулах санал тавьсан байна.¹²

Эндээс дараах хоёр гол дүгнэлт хийж болох юм. Нэгдүгээрт, Япон Манжийн тал БНМАУ-ын нутаг дэвсгэрт зэвсэгт халдлага хийснийхээ дараагаар (1935 оныхтой нэгэн адил) хилийн асуудлыг зохилуулах асуудлаар хэлэлцээ хийх санал тавьдаг, хэлэлцээг сэргээдэг байсан; хоёрдугаарт, эхний хоёр жилийн хэлэлцээний гол зорилго нь Манж-гогийн байнгын төлөөлөгчийн газрыг Монгол улсын нутгийн гүнд байгуулахад оршиж байсан нь харагддаг юм. Үүнийг Манж-го улс өөрийгөө БНМАУ-аар хүлээн зэвшөөрүүлэх бодлогыг тууштай явуулж байсантай холбож ойлгодог.

Ийнхүү хоёр талын санал, чармайлтын дүнд 1936 онд Монгол, Манж-гогийн бага хурлыг сэргээж чадсан юм.

Монгол, Манж-Гогийн III бага хурал

1936 оны энэ бага хурал элдэв шалтгаанаар хойшлогдсоор 1936 оны 10-р сарын 15—1936 оны 12-р сарын 20-нд болж, нийтдээ 20 удаа хуралтсан байна. Уг бага хуралтай холбоотой зарим нэг баримтыг үзье.

Баримт 1. «Манж-гогийн Засгийн газар 1936 оны 4-р сард Японы заавраар тэдний өөрсдийн нь томилон байгуулсан Хойд Хянганы мужийн монгол засаг захиргааг БНМАУ-тай нэгдэх бодолтой байв хэмээн хэн ч үнэмшихгүй ял тулган буудан алав»¹³ гэсэн мэдээ дэлхийн хэвлэлд тарсан байна. Учир битүүлэг энэ байдлын улмаас Манж-го улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн юм. Монгол, Манж-гогийн III бага хурлын талаар «Манжуурын өдрийн мэдээ» сонинд нийтэлснээс үзвэл Манж-гогийн төлөөлөгчийн тэргүүнээр Хойд Хянганы гарнизоны командлагч, генерал Үржин, гишүүдэд Хойд Хянганы мужийн захирагч, генерал Эрхэмбат, Манж-Гогийн Гадаад явдлын яамны улс төрийн асуудал эрхэлсэн товчооны захирал ноён Инахо Кикутаке нар томилогдсон байна¹⁴. Өмнөх бага хуралд оролцсон төлөөлөгчдөөс генерал Үржин л хэвээр үлдэж, улмаар бусдыгаа ахалсан бололтой.

Баримт 2. Японд суугаа ЗСБНХУ-ын бүрэн эрхт төлөөлөгч Юренев 1936 оны 4-р сарын 23—27-нд Японы ГЯЯ-ны сайд Аритатай уулзаж Манж-го, БНМАУ-ын хооронд хилийн комисс байгуулах нь ихээхэн ач холбогдолтой гэдгийг анхааруулахын хамт хэрэв хэлэлцээ үр дүн өгөхгүй бол энэ асуудлыг Ариатад дахин тавина гэдгээ мэдэгдсэн бай-

На¹⁵. Үүнээс үзэхэд Монгол-Манж-гогийн хилийн хэлэлцээний цаана ЗСБНХУ, Япон улс байсан бөгөөд тэдний тодорхой байр сууринаас уг хэлэлцээний үр дүн ихээхэн шалтгаалж байсан болов уу гэж үзэж болохоор байна.

Баримт 3. Японы ГЯЯ-ны сайд Арита 1936 оны 5-р сард парламентын 69-р чуулган дээр хэлсэн үгэндээ: «Одоо Манж-го ба Гадаад Монголын хооронд шууд хэлэлцээ хийж байна. Надад мэдэгдсэнээр Манж-гогийн Засгийн газар хэлэлцээний явцад тодорхойгүй байгаа янз бүрийн асуудлыг нөхөрсгөөр шийдвэрлэж, Гадаад Монголтой сайн хөршийн харилцаа тогтоох бодолтой байна»¹⁶ гэж мэдэгджээ.

Энэ баримтаас үзэхэд Монгол Манж-Гогийн II бага хурлыг 1936 оны 5-р сарын эхээр эхлүүлэхээр төлөвлөж байсан бололтой. Бас энэ хэлэлцээг амжилттай болгохыг Японы Засгийн газар ямар нэг хэмжээгээр сонирхож байсныг гэрчлэх болов уу.

Баримт 4. БНМАУ, Манж-Гогийн хооронд 1936 оны 9-р сарын 16-ны өдөр хил дээр (Хэрлэн голын районд) олзлогдогсдыг харилцан солилцсон байна. Олзлогсдыг солилцох Япон-Манжийн комиссын дарга дэд хурандаа Миязаки 1936 оны өвөл Монголын нутагт довтлох үеэр олзлогдсон 12 цэргийг Монголын талд шилжүүлжээ. Монголын тал 1936 оны 3-р сард БНМАУ-ын нутагт олзлогдсон Япон-Манжийн 12 дарга, цэргийг тэдэнд шилжүүлэн өгсөн байна.

Баримт 5. БНМАУ, Манж-гогийн төлөөлөгчдийн хооронд нэлээд удаан хэлэлцээний эцэст 1936 оны 10-р сарын 29-нд Японы талд тэдний 11 хүний шарилыг шилжүүлсний дотор дэслэгч Харамото болон хоёр унтер-офицерын шарил байв.

Олзлогдогсдыг солилцож, амь үрэгдэгсдийн шарилыг Японы талд шилжүүлснээр Монгол, Манж-гогийн бага хурлыг эхлүүлж явуулахад бас нэг түлхэц болсон нь дамжиггүй. Монгол, Манж-гогийн энэ бага хурлыг бэлтгэхтэй холбогдсон өөр тодорхой баримт энэ хэр бидэнд үгүй байгааг тэмдэглэе. Бага хурлын хэлэлцэх асуудал нь Монгол, Манж-гогийн холимог комисс хоёрыг байгуулах, үүний нэг нь БНМАУ, Манж-гогийн одоогийн хилийн шугамыг шалгах, нөгөө нь хилийн мөргөлдөөний шалтгаан нөхцөлийг судалж байх үүрэгтэй. Сүүлийн комиссыг байгуулахын хамт хоёр талын бүрэн эрхт төлөөлөгч томилж, тэдний байрлах газрыг шийдвэрлэх ёстой байв.

Монголын төлөөлөгчдийн тэргүүн, гишүүдийн бүрэлдэхүүнд ч өөрчлөлт гарчээ. Бага хурлын эхний үед корпус командлан захирагч Г. Самбуу ажиллаж байгаад Ардын Сайд нарын Зөвлөлийн 1936 оны 12-р сарын 4-ний өдрийн тогтоолоор чөлөөлөгдөж, оронд нь Бүх цэргийн жанжны нэгдүгээр орлогч, Корпус командлан захирагч Лхамхүүгийн Дарьзавыг Монголын төлөөлөгчдийн тэргүүнээр томилжээ.¹⁷ Төлөөлөгчдийн гишүүдэд МАХЦ-ийн Дорнод 1 корпусын комиссар Гэндэнжавын Лут-Очир, БНМАУ-ын прокурор Мөрдэндэвийн Ядамсүрэн, нарийн бичгийн дарга Пүрэвдорж, эмч Шагдар, комендант Довчин зэрэг нөхөд шинээр очжээ.

Бага хурлын 1936 оны 11-р сарын 28-наас 12-р сарын 20-ны хуралдаанд Л. Дарьзав оролцсон байна.

Монгол, Манж-Гогийн 1937 оны IV, V бага хурал

Энэ удаагийн бага хурал 1937 оны хавар, мөн 8—9-р сард үргэлжилжээ.

БНМАУ-ын дорнод хил дээр 1937 оны эхээр хилийн мөргөлдөөн үргэлжлэн гарсаар байсныг дараах баримт нотолж байна.

1937 оны 1-р сарын 13-нд мөн тэнд 10 ачааны машин бүхий 200 цэ-

рэг хилд орсон, бас өдөр Японы нисэх онгоц Үхэрт нуурын орчмоор БНМАУ-ын нутагт 70 км-ийн гүнд нислэг үйлдэв.

Хил дээр болсон эдгээр хэрэг явдлыг нэгэн тийш болгохыг шаардаж, Монголын Засгийн газар 1937 оны 1-р сард Манж-гогийн Засгийн газарт 2 удаа нот явуулсан боловч хилийн орчны газар орны байдал, нэр тодорхойгүй гэдгээр шалтаглан Япон-Манж-гогийн цэрэг Монголын нутаг дэвсгэрт эзэлсэн газартаа хэвээр суусаар байв.

Мөн оны 5-р сарын 27—29-нд 4 дэх удаагийн хэлэлцээний 22, 23 дугаар хуралдаан болсон боловч Манж-гогийн төлөөлөгчдийн тэргүүн Үржин Гармаев өвчтэй гэх шалтгаанаар Хайларын цэргийн тойргийг байцаан шалгахаар одсон тул Монголын төлөөлөгчид 1937 оны 6-р сарын 10-нд Улаанбаатарт эргэж ирсэн байна.

Бага хурлын 5 дахь удаагийн хэлэлцээний 24—36 дугаар хуралдаан 1937 оны 8-р сарын 3-наас 9-р сарын 9-нд болжээ. Эдгээр хуралдаанд Монголын төлөөлөгчдийг Самбуу тэргүүлсэн байна. Гэвч БНМАУ-ын Засгийн газрын 1937 оны 9-р сарын 2-ны тогтоолоор түүнийг ерөнхий сайдын 2-р орлогчоор томилсон тул тэрээр 9-р сарын 1-нд Манжуур өртөөнөөс Улаанбаатарт буцаж сүүлийн гурван хуралдааныг Г.Лут-Очир даргалжээ.

Энэхүү хэлэлцээний гол үр дүн бол Монгол, Манж-го хоёр улсын хоорондох хилийг шалгах тухай гэрээний төслийг зүйлчлэн хэлэлцэж түүний 1, 2-р зүйлийг баталсанд оршино. Гэрээний I зүйлд: «БНМАУ ба Манж хаант улс хоёрын хооронд байгаа хил хязгаарыг шалган тодорхойлж, үүнд өнө урьдын хилийг уг газар дээр нь тодорхойлох үүрэгтэй хоёр улсаас хавсаргасан комиссыг байгуулна. Эл комисс нь түүнд даалгасан зорилго үүргийг хоёр улсын хил хязгаарын бэлхэн байгаа баримтуудаар үндэслэж шударга бөгөөд найрамдах сайнаар гүйцэтгэнэ»¹⁸ гэж заасан байна.

Харамсалтай нь, сталинизмын балмад бодлогын дүнд БНМАУ-д тогтоод байсан Х.Чойбалсангаар толгойлуулсан Дотоод явдлын яамны харгис дарангуйлал туйлдаа хүрч, «Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллага» гэгч зохиомол хэргийг бий болгоод 1937 оны 9-р сарын 10-наас эхлэн төр, засаг, цэргийн дээд удирдлагыг «Японы тагнуул төлөөлөгч» хэмээн улс төрийн хилс хэрэгт хоморголон баривчилж эхэлсэн юм. Энэ хууль бус баривчилгааг эхлэх нэг шалтаг нь 1935 оны 6-р сараас эхлэн Гэндэн, Дэмид нар Манжуур дахь Японы штабын төлөөлөгчтэй харилцаа байгуулж байсан»¹⁹ гэж үзсэн байна.

Энэ хэрэгт холбогдуулан БНМАУ-Манж-гогийн хилийн хэлэлцээрийг толгойлж байсан Г.Самбуу, Л. Дарьзав болон төлөөлөгчдийн гишүүдийг бараг толгой дараалан баривчилсан нь уг хэлэлцээрийг дуусгахад ихээхэн хор хүргэж, уг чанартаа түүнийг тасалдуулах нэг шалтгаан болжээ.

Хэлэлцээ 1938 онд үргэлжилсэнгүй. Харин Монгол-Зөвлөлт, Япон Манж-гогийн хооронд 1939 оны хавар, зуны турш 4 сар үргэлжилсэн зарлаагүй дайн Монголын дорнод районд явагдсан нь «Халхын голын байлдаан», «Номонханы хэрэг явдал» зэрэг нэрээр түүхэнд орсон билээ.

Зөвлөлт-Монгол, Япон-Манж-Гогийн хилийн хэлэлцээ (1939—1940)

Халхын голын байлдаан дууссаны дараа дайтагч талуудын дунд БНМАУ, Манж-Гогийн хилийг тодотгох асуудал дахин тавигдлаа.

ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В. Молотов, Москвад суугаа Японы элчин сайд Того нар. 1939 оны 9-р сарын эхээр хэд хэдэн удаа уулзаж, дайныг зогсоох болон Монгол, Манж-гогийн хилийн

асуудлаар ярилцаж тохирсон байна. Тэд 1939 оны 9-р сарын 13--15-ны хооронд доорх асуудлаар хэлэлцэн тохирчээ.

1. Япон-Манж, Зөвлөлт-Монголын цэрэг 1939 оны 9-р сарын 16-ны 02.00 цагаас (Улаанбаатарын цагаар 07.00) байлдааны ажиллагааг зогсоох;

2. Хоёр тал 1939 оны 9-р сарын 15-ны 13.00 цагаас (Улаанбаатарын цагаар 18.00) хойш тус улсын эзэлсэн байрандаа үлдэх;

3. БНМАУ, Манж-гогийн хилийг тодотгох зорилтоор хоёр талаас тус бүр 2 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг аль болохоор түргэн байгуулж, ажилд нь оруулах явдал байв²⁰. Энэ нь БНМАУ, Манж-гогийн хилийн асуудлаар урьд хийж байсан хэлэлцээг дөрвөн талын болгож, уг чанартаа Зөвлөлт-Японы хэлэлцээний шинжтэй болгосон юм.

Үүний дараагаар Монгол, Манж-гогийн хилийн маргаантай хэсгийг судалж тодотгох, хэлэлцээнд талуудын баримтлах бодлогыг тодорхойлох ажил эхэлжээ. Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэх хэрэгтэй юм. Учир нь 1939 оны 9-р сарын 15-нд фронт дээр байлдааны гал зогсоох үеэр БНМАУ-ын нутаг дэвсгэрийн зарим хэсэг, тухайлбал, Нөмрөгийн голын зүүн район Япон-Манжийн цэргийн байрлалд үлдсэн байна.

Мөн бригад командлан захирагч М. Богданов ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В. Молотовт 1939 оны 11-р сарын 4-нд бичсэн илтгэлээ:

— 1939 оны 8-р сарын 24-нд Японы батальон хүртэл явган цэрэг, нэг морьт сумантай ирж Мана уулыг эзэлсэн (Нөмрөгийн голын район Д. Г.);

— 1939 оны 8-р сарын 31-нд Нөмрөгийн голын районоос хил зөрчигчдийг хөөн гаргах үүрэгтэй Зөвлөлтийн ангийг явуулсан; -

— 1939 оны 9-р сарын 12-нд япончууд энэ районд ихээхэн хүч татан ирүүлээд улмаар Монгол-Зөвлөлтийн цэргийг уг голын баруун эрэгт шахаж гаргасан;

— 1939 оны 9-р сарын 16-нд Армийн I бүлгийн командлал тэднийг (япончуудыг устгах байлдааны төлөвлөгөө боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байхад байлдааны гал зогсоох тушаал авсан тул Нөмрөгийн голын зүүн эргийн нутаг Японы талд үлдсэн гэж бичсэн бий.²¹

Энэ нөхцөл байдалд ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В. Молотов, Москва дахь Японы элчин Того нар БНМАУ, Манж-го улсын хооронд мөргөлдөөн гарсан районы хилийг тодотгох асуудлаарх Зөвлөлт-Монгол, Япон-Манж-гогийн холимог комиссыг 1939 оны 11-р сарын 19-нд байгуулжээ.

Уг комисс Чита хотод 1939 оны 12-р сарын 7—1939 оны 12-р сарын 25; Харбинд 1940 оны 1-р сарын 07—1940 оны 1-р сарын 30-нд нийт 16 удаагийн хуралдаан хийсэн байна. Хуралдааныг Зөвлөлтийн талаас бригад командлан захирагч М. Богданов, Японоос Кубота, Монголоос Жамсран, Манж-гогоос Камеяма нар даргалжээ.

Ийнхүү төлөөлөгчдийн хил тодотгох асуудлаар баримталж байсан санал бодлого эрс өөр байснаас болж уг комиссын ажил зогсжээ.²²

Хэлэлцээ амжилтгүй болсон гол шалтгаан нь нэг талаас номонхан, Нөмрөгийн голын районыг Япон-Манж-гогийн тал хүчээр авах гэсэн оролдлого, нөгөө талаас хоёр талын газрын зураг зөрөөтэй байснаас болсон гэх үндэстэй.

Зөвлөлт-Монголын төлөөлөгчдийн дарга, бригад командлан захирагч М. Богданов 1940 оны 2-р сарын 2-нд хэлэлцээний дүнгийн тухай БНМАУ-ын Засгийн газарт бичсэн илтгэлдээ: япончууд бид нараар заавал буулт хийлгэж хэлэлцээг төгсгөхийг их хүсэж байлаа. Харин

бид Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэрээр буулт хийж чадахгүй байсан болохоор ингээгүй юм²³ гэжээ.

Энэ хэрэг явдлаас хойш таван сарын дараа В. Молотов, Того нар БНМАУ, Манж-го улсын хооронд болсон мөргөлдөөний (Халхын голын байлдаан, -Д. Г.) районы хилийг тодотгох асуудлаар 1940 оны 6-р сарын 9-нд Москвад хоёр талын хэлэлцээ байгуулж, газрын зургийг үндэслэн хилийн шугам тогтоожээ.

Молотов, Того нар БНМАУ, Манж-гогийн Засгийн газруудад өөрийн нэрийн өмнөөс хэлэлцээ хийхийг Зөвлөлт, Японд зөвшөөрсөн хэмээн мэдэгдээд²⁴ энэ асуудлыг Зөвлөлт-Монгол, Япон-Манж-гогийн хил тодотгох холимог комисс шийдвэрлэж чадаагүй нь ЗСБНХУ-аас Японтой, БНМАУ-аас Манж-готой харилцах харилцааг зохицуулахад саад болж байсан гэж өгүүлжээ.²⁵

БНМАУ-ын төр, намын удирдагчид дээр дурдсан Молотов-Того нарын хэлэлцээг тэр үед «Зөвлөлт улсын гадаад бодлогын шинэ ялалт», «аугаа их Сталины гүн санаачилга» хэмээн үнэлж байв²⁶. Харин Зөвлөлт-Японы энэ хэлэлцээ нь Монгол улсын газар нутгийн зохих хэсгийг золиосонд гаргасныг тэмдэглэвэл зохино. Үүний дараагаар «газрын зургийн» хилийг газар дээр нь тодотгон тогтоох Зөвлөлт-Монгол, Япон-Манж-гогийн холимог комиссын хурал 1940 оны 8, 1941 оны 5 6-р сард Чита хотод «харилцан ойлголцох», «үлэмж нөхөрсөг байдалд» болжээ.

Хил тодотгох комиссын даргад: Монгол-Зөвлөлтийн талаас дивиз командлан захирагч Б.Дорж, хурандаа Д. И. Смирнов, гишүүдэд: хошууч Ш. Зонров, ахмад Д.Данзан, И. Г. Петров, В. У. Яковенко, дэд хурандаа И. Я. Коган нар томилогдон ажилласан байна. Тэд 1940 оны намар, мөн 1941 оны зун Монгол, Манж-гогийн хилийг газар дээр нь тодотгон тогтоох ажлаа дуусгаад 1941 оны 10-р сарын 15-нд Харбин хотноо протоколд гарын үсэг зуржээ.²⁷

БНМАУ, Манж-го улсын хооронд 1935—1941 онд завсарлагатайгаар долоон жил үргэлжилсэн хилийн хэлэлцээ ийнхүү төгссөн юм.

1. «Нийгэм журмын зам» сэтгүүл, УБ., 1931, № 33—34 (24—25), 85 дахь тал
2. «Ардын үндэсний эрх» сонин. 25 (1935) оны 1 сарын 26, 28/236.
3. «Ардын үндэсний эрх» сонин. 25 (1935) оны 2 сарын 3, №10/238.
4. «Известия» сонин. 1935 оны 1-р сарын 29, № 24 (5577).
5. Монголын ардын армийн төв, архив. ф. 1, т.3, Хн.273, 19 дэх тал.
6. Мөн Тэнд.
7. МАА-ийн төв архив, ф.1, т.3, хн,273, 8 дахь тал.
8. Мөн тэнд, 25—26 дахь тал.
9. Внешняя политика СССР 1917—1944 гг. Сборник документов. Т.IV, М., 1946, с.564, 566.
10. МАА-ийн төв архив. ф.1, т.3, хн.280, 124 дэх тал.
11. МАА-ийн төв архив, Ф.3, хн,307, 12—15 дахь тал.
12. Мөн тэнд.
13. «Үнэн» сонин. 1936 оны 4-р сарын 10, №43.
14. «Manchuria Daily News». December 15, 1936.
15. «Правда» сонин, 1936 оны 4-р сарын 29, №119 (6725).
16. «Правда» сонин. 1936 оны 5-р сарын 12, №129 (6735).
17. БНМАУ-ын түүхийн төв архив. Ф.1, т.2, х,Н, 594, 178 дахь тал
18. Гадаад харилцааны архив. Ф.119, т. 32, х,н, 41,50 дахь тал.
19. Х.Чойбалсан. Илтгэл ба өгүүллүүд.1, УБ, 1951, 497 дахь тал.
20. «Известия» сонин. 1939 оны 9-р сарын 16, №215 (6985). Внешняя политика СССР 1917—1944 гг. Сборник документов. Т. IV, М., 1946, док. №328, с. 418—426,
21. ЦГАСА. Ф. 33987, од, 3, док, 118, п. 314, 316,
22. БНМАУ-ын Гадаад харилцааны архив. Ф. 119, т. 32, Х.Н, 67, 1—6 дахь тал,
23. БНМАУ-ын Гадаад харилцааны архив, Ф. 119, т. 32, х.н, 65, 5 дахь тал,
24. ЦГАСА, Ф. 25871, оп. 2, док. 32, л, 3,
25. «Известия» сонин, 1940 оны 6-р сарын 10, № 132 (7204).
26. БНМАУ-ын Гадаад харилцааны архив. Ф. 59, х,н. 5, 21 дэхь тал,
27. «Үнэн» сонин. 1989 оны 8-р сарын 19, № 198 (17415)